МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ
(Хот байгуулалт, хотын стандартын газар)

2025 оны 11 дүгээр сарын 27 Улаанбаатар хот

| Д/д | ТЕЗ-ийн үр дүн | Хөтөлбөрийн үр дүн | Бодлогын үндэслэл | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь | Төсөл, арга хэмжээний хэрэгжилт | Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Батлагдсан төсөв сая төгрөг | Батлагдсан эх үүсвэр | Санхүүжилтийн гүйцэтгэл сая төгрөг | Санхүүжилтийн эх үүсвэр | Хариуцах байгууллага | Хэрэгжилт удаашралтай байгаа болон хэрэгжээгүй шалтгаан нөхцөл | ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж | Хөтөлбөрийн үр дүнгийн дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2.2.Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна. | 2.2.1.Авто замын ачааллыг бууруулна. | МУХТЖҮЧ-8.1.3, 9.3.3, ЗГҮАХ-1.1.3.6 | 2.2.1.2."Сэлбэ сэргэлт" төслийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 0 | 10 | Барилгын хөгжлийн төв Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.<br>Төслийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийн техникийн нөхцөлийн асуудлыг хангагч байгууллагуудад уламжлан шийдүүлсэн. Гадна цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбоо дохиолол, усны барилга байгууламжийн зураг төслийг ББСМО ХХК-ийн хийж ирүүлсэнийг төслийг зөвшилцөн хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. | 100 | Ажлын зураг төсөл батлагдсан | 100 | 1,500,000.00 | Гадаад зээл /Үнэт цаас/ | - | - | НХБХСГ | - | | |
| 2 | | | МУХТЖҮЧ-9.2.4, ЗГҮАХ-1.1.4.2 | 2.2.1.3.Явган хүний зам, дугуйн замын бүрэн төлөвлөлтийг хийж, явган зорчигчдод ээлтэй дэд бүтцийг сайжруулах | Арга хэмжээний хэрэгжилт | Хувь | 0 | 100 | Явган хүний зам, дугуйн замын бүрэн төлөвлөлтийг хийж, явган зорчигчдод ээлтэй дэд бүтцийг сайжруулах ажлын хүрээнд Замын хөгжлийн газартай хамтран Нийтийн эзэмшлийн явган хүний зам, дугуйн замын зураг төсөл боловсруулах 2501010345 дугаар бүхий ажлын даалгавар батлагдсан. Тухайлсан 3 байршилд явган хүний зам, 7 байршилд авто машингүй гудамжны авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлагдсан . | 100 | Зургийн даалгавар батлагдсан | 100 | - | - | - | - | НЗХГ, ХБХСГ | - | | |

ТАНИЛЦСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДАШЦЭЦЭГ

НЭГТГСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ЭНХТУУЛ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН Л.АДЪЯАСҮРЭН

9024050025
2117401 СБТ24872

## 2.4.ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

2025 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэгч байгууллага | Төсөл, арга хэмжээний нэр | Тайлбар | Боловсруулсан эсвэл шинэчилсэн эсэх | Боловсруулсан эсвэл шинэчилсэн огноо | Боловсруулсан эсвэл шинэчилсэн нийт өртөг (сая.төг) | Боловсруулсан эсвэл шинэчилсэн гүйцэтгэгчийн нэр | ТЭЗҮ, зураг төслийн нэр | Үр дүн (ТЭЗҮ, зураг төсөл ашиглаж хэрэгжүүлсэн арга хэмжээ) | Хэрэгжилт удааширсан болон хэрэгжээгүй шалтгаан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ХБХСГ | Нисэх, Яармаг орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол | Зураг төсөл боловсруулах | Үгүй | Үгүй | 208.3 | Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ | "Яармаг" хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөө | Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/893 дугаар захирамжаар "Яармаг" хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, хөгжлийн газарт тус тус даалгасан. Захирамжийн дагуу 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2023/А/893/01 дугаартай ажлын гэрээ батлагдсан. | Гүйцэтгэгч гэрээний сунгалтын хугацаанд гэрээт ажлыг хүлээлгэн өгөөгүй байх тул гэрээний 7, 9 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэгчид төлбөр төлөх үндэслэлгүй бөгөөд "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай байгуулсан 2023/А/893/01 дугаартай "Яармаг" хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчилсэн боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх" гэрээг цуцлахаар шийдвэрлэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэв. |

(Хот байгуулалт, хотын стандартын газар)

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НОТЛОХ БАРИМТ

2025 оны 11 дүгээр сарын 27 Улаанбаатар хот

## *2.2.1.2.“Сэлбэ сэргэлт” төслийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх*

ББСМО
ЗУРАГ ТӨСӨЛ & ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭСТ

Хаяг: БЗД. 2-р хороо "ББСМО" ХХК-ний оффис
Утас/факс: 77116139. 99116139
E-mail: info@bbsmo.mn

2025.01.28 № 1/16

Техникийн нөхцөл гаргуулах тухай

Манай компани Чингэлтэй дүүргийн 14,18-р хороо, Сүхбаатар дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрийн 158 га талбайд хэрэгжиж буй "Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл, ажлын зураг төсөл, дэд бүтэц гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулан ажиллаж байна.

Мэргэжлийн зөвлөлийн 31 дүгээр хурлаар Сэлбэ дэд төвийн 158 га дахь барилгажилтын төсөл дэмжигдсэн тул гадна шугам сүлжээний зургийн ажлыг эхэлсэн болно.

Нийслэлийн Засаг даргын 1-р орлогчоос 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр бидэнд ирүүлсэн 02-01/260 тоот албан бичгээр өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу "Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн 158 га талбайн барилгажилтын төслийн 2-р хувилбарыг боловсруулан Хот байгуулалт хотын стандартын газрын төлөвлөлтийн асуудал хэлэлцэх 2-р хурлаар дэмжигдсэн. Уг барилгажилтын төслийн 2-р хувилбарын 158 га талбайд барилгажих барилгуудын дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан, мэдээлэл холбооны техникийн нөхцөлүүд авахад шаардлагатай ачааллуудыг урьдчилсан тооцоогоор тооцсоныг хүргүүлж байна.

**Дулаан -** дулааны нийт ачаалал 93.7 МВт буюу 80.6 Гкал/цаг Үүнээс:

Сэлбэ дэд төв-өөс 25.5 МВт буюу 21.93 Гкал/цаг

Дамбадаржаа станцаас 24.16 МВт буюу 20.77 Гкал/цаг

Шинэ эх үүсвэр-ээс 44.34 МВт буюу 38.13 Гкал/цаг

**Цэвэр ус-**10977 м3/хон, **бохир ус-**10977 м3/хон, **галын ус**–25.0 л/с, **технологийн ус**–320.0$м^3$/ц

**Цахилгаан -** цахилгааны ачаалал 44.01 МВт

**Холбоо -** холбооны 96 кор шилэн кабель

Иймд захиалагч байгууллагын зүгээс дээрх ачааллуудын дагуу холбогдох байгууллагуудаас авах техникийн нөхцлийг шийдвэрлүүлж өгнө үү.

ЗАХИРАЛ Б. СҮНЖИДМАА

---

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР**

Наадамчдын зам 1201, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976) 7270 7700
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn

2025.02.04 № 01/131
танай ______ -ны № ______ -т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД

Техникийн нөхцөл хүсэх тухай

Монгол Улсын Их Хурлын 23 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичгийн хүрээнд нийслэлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Сэлбэ дэд төвийн дахин төлөвлөлтийн хүрээнд Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 12637 өрхийн орон сууцны хороолол олон нийтийн барилга байгууламжийн Техник эдийн засгийн үндэслэл, Барилгажилтын төсөл 158 га талбайд баталсан.

Төслийн цахилгаан хангамжийг одоо байгаа 35/10кВ-ын Төгөл дэд станц болон дэд төвийн хүрээнд шинээр төлөвлөж буй 110/35/10кВ-ын дэд станцаас хангахаар төлөвлөсөн. Шинээр төлөвлөж буй 110/35/10кВ-ын дэд станцын байршлыг төсөл хэрэгжүүлэгч ББСМО ХХК Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д танилцуулж ДҮТ ТӨХХК-аар горим тогтворжилтын тооцоо хийлгэж батлуулсан.

Иймд дэд төвийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн нэр дээр гаргаж өгөхийг хүсье. Цахилгаан хангамжийн нийт ачаалал 45МВт.

Хавсралт 1 хуудастай.

Хот байгуулалт хотын стандартын газар
Удирдлага
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ганболд БАЯРСАЙХАН
2025.02.04 14:34

(Хот байгуулалт, хотын стандартын газар)